Тавдугаар сарын 26-наас эхэлсэн ислам шашинтнуудын «Ариун Рамадан сар»-ыг тохиолдуулан Кувейт улсын «Олон улсын исламын энэрлийн сан»-гаас тус аймгийн 273 орход тус бvр 80,000 тогрогийн vнэ бvхий хvнсний тусламж vзvvллээ гэж Монголын Ислам Шашинтны Мvфтият Холбооноос мэдээллээ.

Энэ нь Монгол дахь Кувейт улсын Элчин Сайдын Яамны дэмжлэгээр зохион байгуулагдаж буй 2 дахь хvнсний тусламжийн арга хэмжээ ба 5 дугаар сарын эхэнд мон 437 орход гурил, будаа, хvнсний бусад бvтээгдэхvvн олгосон юм.

Рамадан нь ислам он тооллын 9 дэх сар богоод хvн торолхтний гар дээр Коран судрыг анхлан тавьсан vед тооцогддог. Ислам шашинтнууд нь Рамадан сарын туршид оглоо эртлэн босож, «саре» хэмээх оглооний зоогоо идээд, тухайн одрийн наран жаргатал ганц балга ус ч уулгvй мацаг барьдаг заншилтай. Энэхvv заншлыг нь «Ораза» гэж нэрлэдэг. Энэ одрvvдэд залбирал, уншлагаар оюунаа ундаалах нь махан биеэ тэжээж, юм идэхээс илvv vр ашигтайд тооцогддог байна.

Мон хvн бvр дор бvрнээ сайн vйлс хийж, буяны замыг мордлог болгох нь энэ сарын хамгийн гол заншил юм